



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027

И-мэйл: info@fchm.edu.mn

2024. 08. 22

№

1/1298

танай _____ -ны № _____ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

Г Тайлбар өгөх тухай Г

Тус эмнэлгээс зарласан ЭМЯ/20240102047 дугаар бүхий тендерийн баримт бичигт заасан “инженер бүрийн сургалтад хамрагдсаныг нотлох сертификатууд, болон инженерүүдийг тодорхойлсон үйлдвэрлэгчийн тодорхойлолтыг үйлдвэрлэгч орны нотариатаар баталгаажуулан ирүүлэх” гэснийг “Гадаад орны нотариат биш Гадаад дахь Монголын элчин сайдын яамаар Апостиль хийлгэнэ гэж ойлгох” эсэх талаар тайлбар авахыг хүссэн албан бичигт доорх хариуг өгч байна.

“Инженерүүдийн сургалтад хамрагдсаныг нотлох баримт бичиг болон инженерүүдийг тодорхойлсон үйлдвэрлэгчийн тодорхойлолт”-ыг барааг үйлдвэрлэгч гадаад улсын хууль тогтоомжийн дагуу аливаа үйлдэл, албан ёсны баримт бичгийг гэрчлэх эрх бүхий этгээдээр “нотариат”-ын баталгаа хийлгэх шаардлагыг эмнэлгийн тендерийн баримт бичигт заасан. Ингэснээр тухайн баримт бичгийг “хүчин төгөлдөр, үл маргах шинжтэй баримт бичиг” гэж үзнэ.

Харин гадаад улс дахь Монгол улсын элчин сайдын яам нь тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн албан ёсны баримт бичгийг баталгаажуулж “Апостиль” гэрчилгээ олгодоггүй тул манай эмнэлгийн тендерийн баримт бичигт заасан “нотариатаар баталгаажуулан ирүүлэх” гэснийг “Гадаад орны нотариат биш Гадаад дахь Монголын элчин сайдын яамаар Апостиль хийлгэнэ” гэж ойлгох боломжгүй юм.

Харин гадаад улс дах Монгол улсад суугаа элчин сайдын яам, консулын газраар “инженерүүдийн сургалтад хамрагдсаныг нотлох баримт бичиг болон инженерүүдийг тодорхойлсон үйлдвэрлэгчийн тодорхойлолт”-ыг албан ёсны болохыг баталгаажуулж ирүүлсэн тохиолдолд тухайн баримт бичгийг нотариатаар гэрчлүүлсэнтэй адил “хүчин төгөлдөр, үл маргах шинжтэй баримт бичиг” гэж үзэх боломжтой гэсэн тайлбарыг өгч байна.



ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ХИШИГЖАРГАЛ

002275